



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/БН

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.5.8 дугаар зорилт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11, 2023 оны 41 дүгээр тогтоолууд, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 40 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, "Шинэ сэргэлтийн бодлого" зорилтыг танилцуулах, 2020-2024 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрт иргэдийн санал санаачилгыг сонсож тусгах, төрийн үйлчилгээг хөдөөгийн малчид, иргэдэд хүргэх ажлын хүрээнд явуулын ахуй үйлчилгээг малчдад хүргэх, Монгол эрийн гурван наадмыг уламжлал болгон зохион байгуулах болон бусад үйлчилгээний ажилд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 119,648,000 (зуун арван есөн сая зургаан зуун дөчин найман мянган) төгрөгийн зардлыг Засаг даргын ерөнхий дансны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2011 оны
11 дугаар сарын 27-ны өдрийн 111 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/Д	ЗАРДЛЫН НЭР	ДҮН
1.	Хоолны зардлын үлдэгдэл	3,108,000
2.	Дэлгэц, машин түрээсийн үнэ	50,000,000
3.	Нум, сумны үнэ	28,000,000
4.	Шатахууны үнэ	6,500,000
5.	Эрийн гурван наадмын шагнал	11,880,000
6.	Малчдын үс зассан үйлчилгээний төлбөр	4,160,000
7.	Тэмдэгний үнэ	16,000,000
	Нийт дүн	119,648,000

__оОо__